



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар АЖИЛ

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжих, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Их хангай сууц өмчлөгчдийн холбооны харьяалах 2 дугаар хорооны 7 дугаар байрны дээврийн засварын ажилд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Засварын ажилд шаардагдах 714,000 (Долоон зуун арван дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг хангах ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, дууссанаас хойш 10 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг "Их хангай" сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 26 -ны өдрийн 111/24 дугаар
захирамжийн хавсралт



2 ДУГААР ХОРООНЫ ИХ ХАНГАЙ СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Чулуутай хар цаас	Бо	4	75,000	300,000
2	Чулуугүй хар цаас BLG Техноникель	Бо	2	67,000	134,000
3	Мастик	Лааз	1	110,000	110,000
4	Праймер (1 сав 18 литр)	Лааз	2	65,000	130,000
5	Тээврийн зардлын хөлс	Км	200	-	40,000
Нийт үнэ:					714,000